


Нийт орон нутаг дахь банкуудын активын 42.1 хувийг Орхон, Өмнөговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Дорноговь, Увс аймгууд бүрдүүлжээ.

Зураг 3. Активын бүтэц, аймгуудаар



2016 оны 4 дүгээр улирлын байдлаар орон нутгийн банкуудын активын 90.8%-ийг зээл, 2.8%-ийг касс дахь бэлэн мөнгө, 2.2%-ийг үндсэн хөрөнгө, 4.1%-ийг бусад актив тус тус бүрдүүлж байна.

Зээл


ОНБ-уудын зээлийн үлдэгдэл 2750.4 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.0% буюу 180.5 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх улирлаас 0.4% буюу 11.4 тэрбум төгрөгөөр буурчээ. Орон нутаг дахь банкуудын зээл банкны салбарын нийт зээлийн 23.2%-ийг бүрдүүлж байна.

Зураг 4. Зээлийн өрийн үлдэгдэл, УБ болон орон нутгаар




Зээлийн үлдэгдлийг аймгуудаар авч үзвэл Орхон (ОНБ-ны салбарын нийт зээлийн 8.0%), Дархан-Уул (7.3%), Сэлэнгэ (7.2%), Дорноговь (6.4%), Увс (6.0%), Хөвсгөл (5.4%), Дорнод (5.4%), Өвөрхангай (5.4%) аймгуудын зээл өндөр жин эзэлж байгаа бөгөөд эдгээр нь ОНБ-ны салбарын нийт зээлийн 55.7 хувийг бүрдүүлж байна.

Зураг 5. Орон нутгийн зээл, аймгуудаар



Орон нутагт цалин тэтгэвэр, хэрэглээний зээл нийт зээлийн дийлэнх буюу 60.0 хувийг бүрдүүлж байна. Харин үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт олгосон зээл 15.8 хувь, худалдааны салбарт олгосон зээл 10.1 хувь, хөдөө аж ахуйн салбарт олгосон зээл 7.0 хувь, үлдсэн 7.0 хувь нь бусад салбарт олгосон зээл байна.


Зураг 6. Орон нутаг дахь зээл, салбараар



Чанаргүй зээл өмнөх улирлаас 0.3 хувь буюу 0.2 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 63.2 хувь буюу 28.7 тэрбум төгрөгөөр өсч, 74.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Орон нутгийн нийт зээлийн үлдэгдлийн 95.9% нь хэвийн зээл, 1.4% нь хугацаа хэтэрсэн зээл, 2.7% нь чанаргүй зээл байна.

Зураг 7. Чанаргүй зээлийн хэмжээ, аймгуудаар




Чанаргүй зээлийн хэмжээг аймаг тус бүрээр авч үзвэл Өмнөговь, Увс, Дорноговь, Дархан-Уул аймгуудын дүн хамгийн өндөр бөгөөд нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь харгалзан 5.7%, 5.0%, 4.7%, 4.2% байна.

Ипотекийн зээл

Орон нутагт банкуудын ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл 923.9 тэрбум төгрөг байгаа нь нийт банкны салбарын ипотекийн зээлийн үлдэгдлийн 22.9 хувийг бүрдүүлж байна. Нийт зээлдэгчдийн тоо 28587-д хүрчээ. Энэ нь нийт банкны салбарын орон сууцны ипотекийн зээлдэгчдийн 32.1 хувь юм.


Зураг 8. Ипотекийн зээлийн санхүүжилт, хувь



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 80.3% буюу 742.1 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 18.8% буюу 173.5 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 0.9% буюу 8.2 тэрбум төгрөг нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна. 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.95 хувь нь төгрөгийн зээл байна.

Орон нутаг дахь банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн эзлэх хувийг аймгуудаар авч үзвэл Орхон аймагт 14.1%, Дархан-Уул аймагт 13.9%, Дорнод аймагт 6.5%, Увс аймагт 5.7%, Сэлэнгэ аймагт 5.4%, Өвөрхангай аймагт 5.1% нь ногдож байна.

Зураг 9. Ипотекийн зээл, аймгуудаар



Орон нутагт олгогдсон ипотекийн зээлийн зээлдэгчдийн тоо 28587 байгаагаас 19916 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд хамрагдсан байна. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 16.6 жил байгаа бөгөөд банкууд 1-30 жилийн хугацаатай зээл олгож байна. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү нь 11.2% байв.


Бусад актив

Орон нуггийн банкны салбаруудад зээлээс бусад актив хөрөнгө харьцангуй бага байдаг бөгөөд бэлэн мөнгө нийт активын 2.8 хувь, үндсэн хөрөнгийн хэмжээ нийт активын 2.2 хувь бол бусад актив 4.1 хувийг бүрдүүлжээ. Мөн хуримтлуулж тооцсон хүүний авлага, салбар хоорондын тооцооны авлага зэрэг нь бусад активт бүртгэдэг.

Хүү

Тайлант улирлын байдлаар орон нутаг дахь банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү 18.6 хувь байгаа нь улсын дунджаас 1.2 нэгж хувиар бага байна.


Зураг 10. Орон нутаг дахь зээлийн хүү



*Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээлийг оруулсан ЖДХ

Орон нутаг дахь банкуудын зээл, хадгаламжийн хүүний зөрүү 1.9-7.0 нэгж хувийн хооронд байгаа бөгөөд хамгийн их зөрүүтэй аймагт Сэлэнгэ, Хэнтий, Төв, Хөвсгөл аймгууд буюу 6.1-7.0 нэгж хувь байна.

Зураг 11. Зээл, хадгаламжийн хүү /аймгуудаар/



Тайлант улиралд харилцах дансны жигнэсэн дундаж хүү жилийн 2.3%, хадгаламжийн хүү 14.5%-тай байна. Булган, Хэнтий аймгуудын банкуудын харилцахын ЖДХ 3.7% буюу хамгийн өндөр хүүтэй байлаа.

Тайлант улиралд Баянхонгор аймгийн банкуудын хадгаламжийн жилийн жигнэсэн дундаж хүү 15.8% буюу хамгийн өндөр хүүтэй байна. Мөн Архангай (15.6%), Увс (15.5%), Өмнөговь (15.2%) аймгуудын банкуудын хадгаламжийн данс хамгийн өндөр хүүтэй байна.

Орон нутаг дахь банкны салбар нэгж, хүний нөөцийн байдал

2016 оны 4 дүгээр улиралд 12 банк 1052 салбар, нэгжээрээ дамжуулан хөдөө орон нутагт банкны үйлчилгээг хүргэж байна. Үүнээс ХААН (23 салбар, 412 тооцооны төв, 5 хадгаламжийн касс, 30 явуулын касс, валютын цэг, нийт 470 салбар, нэгжтэй), Төрийн банк (23 салбар, 387 тооцооны төв, 14 хадгаламжийн касс, 8 явуулын касс, 2 валютын цэг, нийт 434 салбар, нэгжтэй) хамгийн олон салбар, нэгжтэй байна.

Тайлант улиралд орон нутаг дахь банкны салбар 5754 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 5175 ажилтан дээд, 214 ажилтан тусгай дунд, 322 ажилтан бүрэн дунд боловсролтой байгаа бол мэргэжлийн хувьд 3776 нь мэргэжлийн, 1710 нь бусад мэргэжилтэй, 268 нь мэргэжилгүй ажилтан байна. Харин хүйсийн харьцааны хувьд 33.0% нь эрэгтэй, 67.0% нь эмэгтэй ажилтан байна.